



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/92

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Амаржих газрын “Нярайн эмгэг судлал”-ын тасаг байгуулахад 500.0 мянган, Булган сумын нэгдсэн эмнэлгийн шинэ барилгын нээлтийн үйл ажиллагаанд 500.0 мянга, нийт 1 000 000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 1 000 000 төгрөг (Нэг сая)-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.12 дахь заалтын “Эрүүл мэндийн эрсдлийг бууруулах” төсөл, хөтөлбөрийн зардлаас тооцож олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Уранчимэг/-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

